

ТҮРЭГ МОНГОЛ ХЭЛНИЙ ЗАРИМ ҮГИЙН ГАРЛЫН ТУХАЙ

М.Ууганбаяр

М. Рясянен уйгур цагаадай кумык зэрэг хэлний аš “хүнс, хоол, идээ” гэсэн утга, уйгур куман казань татар хэлний “зочннд барих зоог, найр хурим” осман түрэг хэлний “гурилаар амталсан шөл”, ойрд буюу алтай телеут хэлний үр тариа үрийн талх, талх зэрэг утга > чуваш хэлний аš мах камасин самоед хэлний аš “хөх тариа”, караим хэлний уйгур хэлний таранчи аялгуу зэргийн аšā якут хэлний аšā идэх цагаадай крым татар хэл казань түрэг хэлний аša-t тэжээх хооллох телеут хэл, сибирийн татар хэлний бараба аялгууны азат “зөөлөрсөн эсэг хөрөнгөөр арчсан арьс”, черемис буюу мари хэлний аšn-āsn тэжээх асрах аš-la “идэх уух, эрүүл энхийн төлөө уух, арьс идээлэх”, дундад зууны түрэг хэлний аš-la-k “хоол идээ”, сибирийн татар хэлний тоболь аялгууны аšlau “хотгор, хөнднй, тэвш, онгоц” казах хэлний аš-tau > вогуль буюу манси хэлний оslх дундад зууны түрэг хэлний аš-lyk “гал зуух, хоол, хүнс”, балкар хэлний аšlyk вогуль буюу манси хэлний аšlau “үр тарианы талх, талх, үр тариа, гал зуух”, аš-hāna hāna < перс аš-pāz bāz < “тогооч”, монгол хэлний alisun буурцаг хураах *ali үр тариа солонгос хэлний al үр үр тариа гэсэн жишээг харьцуулжээ (1969: 29).

В.Г.Егоров чуваш хэлний аш гэх үгийг мах гэсэн утгатай ба аш-какай, аш-паш гэх хам утгаар аливаа махыг заана гээд эртний түрэг хэл болон Замахширын “Мукаддимат ал-Адаб” толь, XII-XIII зууны дундад Азийн тefсирт тохиолдох азук, “хүнс тэжээл” цагаадай хэлний ашлыг “үр тариа, үр тарианы талх”, Кашгарын Махмудын Дивану люгат ат тюрк толь, уйгур киргиз ногай хэл болон түрэг аман хэлний аш казах ногай хакас хэлний ас, балкар хэлний аш-маш” хоол идээ хүнс”, туркмен каракалпак, ногай хэлний азык якут хэлний ысык узбек хэлний ош “халуун хоол, идээ, полоов, будаатай хуурга”, ойрд буюу өмнөд алтай хэлний аш хоол идээ тарианы түрүү үр тарианы талх хакас хэлний ас “үр тариа”, татар хэлний ашлык киргиз хэлний аштык амуу тариа уйгур хэлний ашпээ казах, хакас хэлний аспаз, узбек хэлний ошпаз “тогооч”, киргиз, татар, башкир хэлний аша-“идэх”, перс хэлний аш “шөл бантан зутан сөмс, хоол идээ цардуул цавуу”, аш-паз “тогооч” гэх үгтэй харьцуулсан ба чуваш хэлний аштар гэх үйлдүүлэх үйл үгийн хэлбэр адууг шон тойруулан уяагаар адууг тууж тариа цохих гэсэн утгатай байна (1964: 38).

Юдахины киргиз орос тольд аш хэмээх үг хоол идээ хүнс, аш тарт подносит идг зочинд ойртуулж өгөх хүргэж өгөх кескен аш лапша суюкаш умач аш гэвэл гурилан шөл, арак аш гэвэл цагаан архи гэх утгыг гэх утгаас гадна жимс гэсэн утгатай бөгөөд зааж хэдэн зэрлэг ургамлын нэрийг заан хэрэглэгдэж буй бөгөөд четиндин ашы нь тэс модны жимс, ит мурундун ашы нь нохойн хошууны жимс, чычырканактын ашы нь чацарганын жимс сары жыгачтын ашы нь шар модны жимс буюу бөрү карагат тошлогийн жимс гэсэн утгатай ажээ (КРС, 2019: 90, 387).

Хасан Эрен, П.Пеллио перс хэлний āš “хоол, хүнс, идээ зоог, шөл, хар шөл, өтгөн шөл, агшаамал овьёос” гэх үг түрэг хэлнээс зээлэгдсэн гэж, Л. Лигети ч перс хэлний āš гэх үгийг түрэг хэлнээс зээлэгдсэн гэж үзсэн тухай бичжээ (2000: 23). Түрэг хэлний аш “идээ хүнс, талх”-ийг Рамстедт монгол хэлний alisun “альс”, таримал вандуй” <*ali үр тариа солонгос хэлний al үр, тариа, эрдэнэ шиш гэх хэлбэрүүдийг нэгтгэсэн (1952: 109, 139, 1949: 6-7). Йоки мөн л Рамстедт лүгээ адил бодолтой бөгөөд харни alisun гэх үг орчин монгол хэл аялгууст хэрэглэгдэхгүй

болохыг бичжээ (Йоки, 1952:78). Дёрфер дундад зууны перс хэлний āṣ “хоол хүнс, шөл, агшаамал овъёос” гэх хэлбэрийн тухай дурджээ (1965: 481). В.Котвич манж хэлний аш “үмхэх, амандаа хийх зажлах” гэх үгийг түрэг зээллэг гэж үзжээ (1939: 98) (Лувсанжав нар 1968:12).

Э.В.Севортян дундад зууны иран хэлний аш “шөл” хэмээх үгээс үзвэл, түрэг хэлний энэ үгийн хувьд шөл бантан зутан сөмс, чанасан хүнс, махан төдийгүй ургамлын чанамал хоол гэсэн утга хамгийн анхны утга байж магад, мөн хамгийн эртний түрэг хэлний дурсгалд буй хоол идээ хүнс гэсэн ерөнхийлсөн цор ганц утга эртний утга байх хангалттай боломжтой. Энэ утга азербайжан хэлнээс бусад хэлний илрэх нийт түрэг хэлний утга юм. Гэхдээ түрэгийн ертөнцийн хэлний өргөн уудам нутаг дэвсгэрт ямар замаар цаг хугацааны ямар үед энэ утга түгэн тархсан тухай өгүүлэхэд одоохондоо бэрх билээ. Киргиз казах каракалпак уйгур хэлнээ буй энэ үгийн тахилын идээ улмаар поминки гэх утгыг ч эртний утга гэж тооцох хэрэгтэй. Анх удаа цагаадай хэлнээ тохиолдох дундад азийн бүс нутгийн полоов будаатай хуурга будаа, амс, агшаамал гэх утга ихэд тодорхой харагдана. Энэ утга азербайжан хэлнээ будаа, амс, агшаамал, пилав, будаатай хуурга гэсэн утгаар, мөн түрэг хэлнээ шууд хөрш персүүдээс эсвэл дундад зууны үед туркмен овог аймгуудаар дамжин, нэг бол хожим түрэг азербайжан үндэстнийг үүсгэсэн огуз овог аймгуудаар дамжин бага Ази баруун өмнөд Каспийн тэнгис орчимд өөр өөр замаар нэвтэрчээ. Аш хэмээх үгийн бусад утга тухайлбал зөвхөн кумык, алтай хакас хэлний тархсан талх үр тариа амуу тариа гэх утга илүү хожмын утга юм. Энэ утгад үндэслэн кумык алтай хакас чуудад бусад түрэг ард түмнээс илүү эрт талх газар тариалан хөгжсөн гэж үзэх нь бүдүүлэг алдаа болох ба энэ нь эдгээр ард түмний саяхныг хүртэл эрхэлж асан эдийн засгийн нөхцөл шинж чанартай зөрчилдөнө. Аш, ас хэмээх үгийн нийт түрэг хэлнээ байх хоол идээ хүнс гэх утга явцуурч тодорхой болж нарийссан гэх нь илүү магадтай юм гээд, аш гэх үгийг иран хэлний āṣ, гагауз хэлний а:ш, Кашгарын Махмудын толины āṣ, санскрит хэлний pratarāṣa өглөөний хоол sāyamāṣa оройн хоол гэх үгэнд орох āṣa авест судрын хэлний kahrkāsa Гэхдээ П. Хорн шинэ перс хэлний s санскрит хэлний ś авест судрын хэлний s гэжээ. Улмаар nāṣnā гэх үгтэй харьцуулж болно. Ф.Стейнгассын тольд āṣ хэмээх үгийг санскрит хэлний āṣa лүгээ харьцуулжээ. Аш хэмээх үг пехлевий хэлний маш эртний зээллэг болох нь эртний үг бүтэх ёсны нэр үг –үйл үг гэх загвараар үүссэн одоо түрэг хэлнүүдэд үгүй болсон аш хэмээх ижил үйл үг байгаагаар дам нотлогдож байна. Ашыч<*аш-+-ич хэмээх хэрэглүүрийн утгатай залгавар тогоо ногой хэлний асым < *ас-+-ым гэх хэсэг хувь гэсэн утгатай залгавар башкир хэлний аскак “ховдог”, Т.Ценкер түрэг хэлний ашмак ушмак гэсэн үгийг харуулсан нь бичиг үүсэхээс өмнөх үеийн тусах эс тусах утга ялгараагүй илүү эрт хэлбэр гэж дурджээ (Севортян, 1974: 210-212).

Азербайжан хэлнээ аш нь “пилав, будаатай хуурга” гэх утгатай ба ашбашы “пилавын амтлагаа, хольц”, ашырмаг “идэх, гудрах”, ашпаз “тогооч”, ашпазбашы “ахлах тогооч”, ашпазлыг “тогоочийн мэргэжил, хоол зүй”, ашпазхана “гал тогоо, хоолны газар, гуанз”, ашхана “гуанз, ресторан”, ашханачы “гуанз хоолны газрын эзэн” гэх үгс байна (АРС, 1985 45-46). Татар хэлнээ аш гэх үг “шөл халуун нэгдүгээр хоол, хоол, идээ, хүнс”, аш бүлмәсе гуанз, гал зуух аш кашыгы “хоолны халбага”, аш пешерүче “тогооч”, аш сенү “хоол чанах”, аш тозы “хоолны давс”, аш чүмече “шанага”, аш өе “гал зуух”, аш өстәле “үдийн хоолны ширээ”, ашыгыз тәмле булсын “тавтай хооллоорой “ашын ашаган яшен яшәгән “он жилүүдэд, зундаа”, ашалучан “үлэмж хэрэглэгдэх, илүү их идэгдэх”, ашамлык “хоол, хүнс, идээ, зоог, идэш, идэх юм, бүтээгдэхүүн”, ашамсак ашамчак “идэх дуртай, гурман, хоол идээний чанар амт мэдэх хүн”, ашарга “идэх зооглох, идэх, зэв идэх, мэрэх, хорхой идэх, казах, хатгах, ус идэх, ус нураах, ус эвдэх, онгох, гандах, нар идэх”, ашап алырга “идээд авах, идэчхэх, жаахан идэх, казах, зуух”, ашап бетерергә “идэж дуусгах”, ашап карарга “амсах амтлах”, ашап туярга “идэж цадах, идэж ханах”, ашарга яраксыз “идэхэд ашиггүй”, ашатучы “тэжээгч”, ашатырга “тэжээх, хооллох, дайлах, зочлох, тариа өвсийг гишгүүлэх”, ашау “идэш, хоол”, ашаучы “долгонцог, хоолонцор хүн”, ашау-эчү “хоол хүнс тэжээл”, ашказаны “ходоод”, ашлык “талх, тариа, үр тариа”, ашлык

бурасы “үр тарианы агуулах”, ашлык киптергеч “тариа хатаагуур”, ашлык кыры “тариалан, тариалангийн газар”, ашлык сугу “тариа цохих, тариа түгших”, ашлык суыргыч жилгэргеч “тарианы хийсгүүр”, ашлык унмау “ган гачиг, ургацгүй, ургац тарчиг, ургац муу”, ашлы-сулы “баян чинээлэг хүрэлцээтэй, зочломтгой”, аш-су “хоол, хүнс, идээ, зоог, талх-давс, зочдын ширээ”, аш суга оста булырга, “хоол сайн бэлдэж чадах”, ашханэ “гуанз, хоолны газар”, ашчы “тогооч” гэхчлэн хэрэглэгдэж байна (1995: 42-43).

Б.И.Татаринцев тува хэлний аьш—чем хоол хүнс, хоол, идээ, үйлдэхүүн, хоол хүнс, гэсэн утгатай байх төдийгүй тофалар хэлнээ ч энэ үг аш нем аш чиишкин “хоол хүнс” гэх утгатай гэсэн ба гэхдээ энэхүү аш гэх үг тува хэлний зөвөөн энэ хоршоо үгнээ тохиолдох ба бие дааж хэрэглэгддэггүй юм. Энэ үг лүгээ нийт түрэг хэлний аш ас зарим түрэг хэлний үгийн эхний анхдагч урт эгшигтэй ааш “хоол идээ. идэш хоол шөл будаа полоов, цагаан будаатай хуурга” гэх үг тохирно” гэв.

Б.И.Татаринцев аш хэмээх үгийг зарим судлаач иран хэлнээс зээлэгдсэн үг гэж үздэг гэхдээ Э.В.Севортян энэ үгийг жинхэнэ түрэг үг байж болохыг дурдсан хийгээд Л.В.Дмитриева ч энэ үгийг түрэг үг гэж үзэж, олон жишээг харуулж В.М.Иллич-Свитычын нострат хэлний үгийн сангийн зэрэгцэлтэй нэгтгэсэн гээд Дмитриева нарын судлаачдын эвенк хэлний *ala* амттай эвен хэлний *alak-e* “амттай” солонгос хэлний *al* “үр тариа” гэх жишээнд тулгуурласан алтай хэл түрэг хэлний *ал хоол идээ хоол гэх харьцууллыг Татаринцев маргаантай бөгөөд энэ үгийн гарлыг тодруулж чадахгүй байна гэжээ. Татаринцев түрэг хэлний аш хэмээх үгийн хувьд итгүүлэх хүч ихэд тааруу иран зээллэг үг гэх саналаас илүүтэй алтай хэлний бус харин түрэг гаралтай гэх бодлыг илүүд үзэх хэрэгтэй ч энэ үгийн гарал тодорхойгүй юм гэжээ (2000: 160).

М.Фасмер орос хэлнээ ашать идэх гэх үгийг Радловын тольдс ишлэн, түрэг, татар, кыпчак, крым татар, цагаадай хэлний *ašamak* казах хэлний *asamak* аас үүссэн гэв (1986: 98). М.Фасмер орос хэлний яшка “чувашская похлёбка чуваш бантан зутан сөмс” гэх үгийг чуваш хэлний *jaška* “бантан зутан сөмс”, татар, түрэг, башкир, казах хэлний *aš*-аас зээлэгдсэн гэж үзжээ (1987: 572).

Түрэг хэлний аш идэх гэсэн үгээс үүссэн түрэг хэлний *alma* алим монгол хэлний *alima* алим гэх үг иддэг жимс гэсэн утгыг заана.

М.Рясянен уйгур цагаадай хэлний *alma* “алим” осман түрэг хэлний *elma* чуваш хэлний *olma ulma uma* гэх жишээг харьцуулжээ (1969: 18).

В.Г.Егоров чуваш хэлний улма пах улми пан улми йывас улми гэвэл алим, сёр улми улма гэвэл төмс гэсэн утгатай хэмээгээд уйгур, киргиз, казах, каракалпак, ногой, азербайжан, туркмен, татар, башкир хэлний алма, узбек хэлний олма, түрэг хэлний элма, алим, монгол хэлний алим зэрэг үгийг зэрэгцүүлсэн байна. В.Г.Егоров чуваш хэлнээ пах улми гэдэг нь перс хэлний баг цэцэрлэг цэцэрлэгийн алим пан улми гэвэл алтай хэлний ман хашаа хороо, хүрээ, хашаа цээрлэгийн алимыг зааж, варман улми гэвэл ойн буюу зэрлэг алимыг заах аж жишээг бичээд Мункачи түрэг хэлнүүдийн алма нь санскрит хэлний *amla* “гашуун, исгэлэн” гэсэн үг гэж үзсэн хэмээв. В.Г.Егоров чуваш хэлний улма гэх үг анхандаа ойн буюу зэрлэг алимыг зааж байсан байж магад гэв (1964:273).

Алим хэмээх үгийг чуваш хэлнээ улма гэж хэлдэг нь ихэд сонирхолтой ба энэ үг орос хэлний кушать “идэх зооглох”, пожалуйста, кушайте “зооглох ажаамуу” кушанье “хоол идээ”, кусать “казах, зуух, хатгах”, змея кусает “могой хатгана”, түлэх крапива кусает “халгай түлнэ”, кусаться “казах, зуух”, это собака кусается “энэ нохой зуудаг” гэх үгстэй нэг язгууртай байна (Дамдинсүрэн нар, 1982: 239-240).

Энэ үг татар хэлний нутгийн аялгууст төмс гэсэн утгатай юм (ДС II, 1953: 33).

Э.В.Севортян энэ үгийн алима гэх хэлбэрийг илүү эртний хэлбэр хэмээгээд салар хэлнээ алима гэж байх бөгөөд энэхүү алима гэх хэлбэр монгол хэлнээс зээлэгдсэн гэв.

Э.В.Севортян Кашгарын Махмудын толины алмыла хэлбэрийг хамгийн эртний хэлбэр гэж үзжээ (1974: 137).

Э.В.Севортяны өгүүлсэнээс харвал, Бернат Мункачи алма гэх түрэг үгийг энэтхэг европын хэлнээс гаралтай гээд санскрит хэлний *amla* “гашуун” гэх үгтэй холбон үзсэн ба Томашек гэгч хүн энэхүү түрэг үгийг фин хэлний *opena* лив хэлний *umāg* мордва хэлний *umāg maḡ* алим гэх үгтэй харьцуулсан талаар бичсэн ажээ (1974: 137).

Ж.Клаузон Хуа И-И-Юй толины *alima* лийр гэх үгийг эртний түрэг хэлний *alma* алим гэх түрэг зээллэг үг гэжээ (Клаузон, 1959: 306). А.М.Щербак буриад аялгууны *al'ma* “алим” “алимны мод” гэх үгийг түрэг хэлнээс зээлэгдсэн үг гээд эртний түрэг хэлний *alma*, *alimla*, азербайжан, киргиз, караим, уйгур хэлний *alma*, орчин цагийн түрэг хэлний *elma* “Мукаддимат ал-Адаб” толины *alma*, монгол бичгийн хэлний *alima*, монгол хэлний минхэ саньчуань аялгууны *alima amla* халимаг аялгууны *al'mn*, монгол хэлний *alim* “алим”, баоань хэлний *almang* “лийр”, дагуур хэлний *al'm* “алим лийр”, дүншаан хэлний *al'ma* “ногоо жимс” зэрэг жишээг зэрэгцүүлэн харуулсан байна (2005:21).

Го.Зоригт монгол хэлний алим *alima* / *elam*, барга аман аялгууны *alim*, дагуур хэлний *aləm*, зүүн ёгор хэлний *alma* “жимс”, монгол хэлний *aləma*, дүншаан хэлний *alima*, түрэг хэлний *elma* “алмарад”, уйгур хэлний *alma*, казах хэлний *alma*, киргиз хэлний *alma*, узбек хэлний *alme*, татар хэлний *alma*, тува хэлний *alma*, баруун ёгор хэлний *alma* “агалиг алим”, азербайжан хэлний *alma*, башкир хэлний *alma*, туркмен хэлний *alma* гэх жишээгээр монгол хэлний түрэг хэлний гэх хоёр үгийг төрөл гарал нэгтэй дундын үг гэж үзжээ (2000: 134).

Монгол хэлнүүдийн гарал зүйн тольд монгол хэлний *alima* гэх үгийг халх аялгууны алим, буриад аялгууны альма, халимаг аялгууны альмн алим, баоань хэлний алман, дүншаан хэлний аліма, даг. *alim* лийр, хэдмэн, монгол хэлний аліма жимс гэх үгс цаашлаад эртний түрэг хэлний *alma* алим гэх жишээтэй харьцуулжээ (Санжеев нар, 2015: 45).

Цэцэнцогт монгол хэлний *alima* “алим” гэх үгийг навч зулгарах тураг модонд суудаг нэг зүйлийн хүчлэг амттай шүүслэг жимсийг заана гээд лийр ч гэдэг гэв. Цэцэнцогт монгол хэлний энэхүү үгийн *ali-* язгуур лугаа *aliusu* “алиус”, *alima* “алим”, *alisu* “альс”, *alisulaqu* “альслах”, *alisam* “альсам”, *nališam ališam* “налишам” *yarma alirsu alma almarad eliüsü* гэх үгс ижилсэнэ гэжээ. харьцуулжээ (1988: 96-97).

Цэцэнцогт монгол хэлний *aliusu* гэх үг ургамлын хур хэнз давжааг хэлнэ гээд *eliüsü* ч гэдэг хэмээгээд *alisu alisun alirsu alirsun* алирс зэрэг жишээг “Бурхан багшийн арван хоёр зохионгуй” зохиолоос ишилжээ. Цэцэнцогт Монголын нууц товчооны *ülirsün* хэмээх үгийг үрэл гэсэн утгатай гээд *üril* хэмээх үгийг алимын модтой адилавар бөгөөд өргөстэй урт шилбэтэй жижиг улаан жимс суудаг навч зулгарах тураг мод улир ч гэдэг, дагуураар одоо бас *ulir* гэдэг гээд үрлийн мод үрлийн цай *üril üiir* Алтан товчид гарах *üril*, мөн монгол хэлний *ülirsün ürilsün* үрэл гэх мэт жишээг харуулжээ (1988: 497).

Монгол хэлнүүдийн гарал зүйн тольд монгол хэлний *alirsun* [**alir-sun*] гэх үгийг халх аялгууны. алирс(ан), бур. алирхан “алирс анис” → эвенк хэлний алерсун “алирс, анис” (Санжеев нар, 2015: 46) гэж харуулжээ.

О.Сүхбаатар монгол хэлний алис гэх үгийг манж хэлнийхээс ирэлтэй гээд гээд хөх өвс, үрлэж боловсроогүй үед ногооноор нь хонгорцогтой нь хадсан буурцагт тарианы өвс гэх утгатайг алиус хэмээх үгийг алистай гарал нэг манж үг гээд үр тариаг хадахад газар унасан үрээс гарсан өвс үерт автуулж дахин ургасан өвс гэх утгатайг алишма гэх үгийг утгаа самгардийн налишам гэдэг үг гэв. Налишам гэдгийг төвөдөөр *na le šam* гэж самгардиар *nalisam* гэдэг байна. Анхилуун үнэрт цэцэгтэй намхан мод *mesua roxburghii* хар чинжүү *riper nigrum* О.Сүхбаатар алмарад гэх үгийг перс үг бөгөөд нэг буюу олон наст ороонго ургамал улаан шаргал өнгөтэй амтлаг гонзгойдуу хэлбэртэй махлаг жимс гэв (Сүхбаатар, 1997:16, 144).

Харин Го.Зоригт монгол хэлний алмарад *almurad/ elmarad* = эртний түрэг хэлний *almila* алмарад, түрэг хэлний *armut* алим, уйгур хэлний *amut* ~ *armut*, казах хэлний *almurt*, киргиз хэлний *almurut*, татар хэлний *amut*, тува хэлний *armurt*, салар хэлний *armurt*, азербайжан

хэлний *armud*, туркмен хэлний *armit* зэрэг үгсийг гарал нэгтэй үг хэмээн үзэж зэрэгцүүлжээ (2000: 152).

Ё.Накашима өвөг түрэг хэл эртний түрэг хэлний *alma-alimla* гэх үгээс монгол хэлний *alima* гэх үг зээлэгдсэн гэв. Тэрбээр өвөг түрэг хэл, эртний түрэг хэлний *alma* гэх үг казах хэл шинэ уйгур хэлнээ *alma* түрэг хэлнээ *elma* чуваш хэлнээ *ulma* гэж байх тухай өгүүлсэн билээ (2007: 33). Ё.Накашима өвөг түрэг хэл, эртний түрэг хэлний *armut* “лийр” гэх үг түрэг шинэ уйгур хэлнээ *armut* гэх хэлбэртэй байх ба харин казах хэлнээ *almurt* киргиз хэлнээ *almurut* “лийр” гэж байж, казах киргиз хэлнээс монгол хэлний *almurad* буюу алим гэх үг зээлэгдсэн гэж үзжээ (2007: 33).

Хамниган-манж хэлний харьцуулсан тольд улиикта “алимын мод” гэсэн хамниган манж нэгдмэл хэлбэрийг сэргээгээд эвенк хэлний улиикта “өрлийн мод”, *ulukta* “монос”, солон хэлний улиитте *улиикте “ойн давжаа алим”, улииттении моо алимны мод, удэй хэлний улингиэ “алим, өрлийн модны үр тэс, сэндэн, ульч хэлний униктэ, унэктэ “алим, өрлийн модны жимс”, нанай хэлний ун’иктэ улиэктэ “өрлийн модны үр, алим”, унункурэ уцмункэрэ зэрлэг өрлийн мод манж хэлний ули “лийр, хэдмэн, жимс” “тэс, сэндэн, хадир”, ули моо “лийрийн мод хэдмэний мод” гээд, монгол бичгийн хэлний *ölir* “зэрлэг алим”, монгол хэлний өрөл “зэрлэг алим”, буриад хэлний үлир “зэрлэг алимны мод зэрлэг алим” гэх үгтэй харьцуулжээ. (ССТМЯ II 1977 261, 264) Энэхүү тольд манж хэлний ули буюу “шар лис, шар чавга” гэх үгийг зээлмэл үг буюу хятад хэлний юили “жигжиг лис, жигжиг чавга” гэх үг гэжээ (ССТМЯ II, 1977: 260).

Го.Зоригт монгол хэлний жимс *jimis / džims*, буриад аялгууны *zims*, ойрд аялгууны *zemis* гэдэг үг нь эртний түрэг хэлний *ye-* идэх, *yem* идэш, түрэг хэлний *ye-*, *yem yemiš* жимс, *yemek* идээ; уйгур хэлний *je-, jem, jimiš*; казах хэлний *dze-, džem, džemis*; киргиз хэлний *dze, džem, džemiš*; узбек хэл: *je-, jem, jemiš*; татар хэлний *jem ~ dzem, jemiš*; тува хэл: *dži-, džem, džemis*; салар хэлний *ji-, jem, jimiš*; баруун ёгор хэлний *ji-, džer, džemas* дотроо жимсний хатаамалтай идээ; азербайжан хэлний *ye-, yem*; башкир хэлний *yim, yimiš*; туркмен хэлний *īu-, ĩum, ĩumiš* зэрэг үгтэй тохирч буй гээд монгол хэлний жимс гэдэг үг авиа утгын талаар түрэг төрлийн хэлний *yemiš* у, *dž*, *s*, *š* зэрэг гийгүүлэгчийн сэлгэцээс болж, түрэг төрлийн хэлэнд дуудлага нь жаахан зөрөөтэй тохирч байгаа боловч, монгол хэлний хэрэглэгдэхүүнд үндэслэж, жимс гэдэг үгийг цаашид бүтцээр задлахад хэцүү юм. Харин түрэг төрлийн хэлэнд байгаа *ye-, yem, yemiš, yemek* зэрэг үг бол цөм *ye-* -ээр язгуур болсон төрөл үг болох нь бүгд ил тодорхой байдаг юм. Түрэг төрлийн хэлний *yemiš* -ийг ердөө *ye-* идэх + *-miš* бүтэцтэй гэж үздэг. *-Miš* бол эртний түрэг хэлний тэмдэг үйлийн өнгөрсөн цагийг илтгэх утгатай дагавар. Ингэхээр *yemiš* гэдэг үг анхандаа идсэн юм буюу иддэг юм гэсэг утгыг илтгэж байсан байх. Гэвч, одоогийн түрэг төрлийн хэлэнд илтгэх утгын хэмжээ нь явцуурч иддэг юмсын доторх нэг зүйл жимсийг нэрлэх болсон байна. Монгол хэлний *dž* гийгүүлэгч түрэг төрөл хэлний у гийгүүлэгчтэй тохирдог. Жишээлбэл: монгол, хэлний жил *džil*, зүс *džus* ба түрэг төрлийн хэлний *yil, yüz* гэх мэт. Тэрчлэн түрэг төрлийн хэлэнд энэ үгийн язгуур дахь эгшиг нь *e, i* гэж бага сага зөрөөтэй байгаа гээд монгол хэлний жимс гэх үгийг түрэг хэлний *yemiš* буюу *yimiš* гэх үгээс үүссэн гэж (2000: 64) үзсэн шиг түрэг хэлний *jemiš* “идэш, жимс”, түрэг хэлний *alma* монгол хэлний алим гэх үг *je-* “идэх”, *al-*, *aš-* “идэх хэсэглэх” гэхчлэн ижил утгатай язгуураас үүссэн нь сонирхолтой юм.

Түрэг хэлний *as* түрэг монгол хэлний *alma alima* алим гэх үг түрэг монгол хэлний *tala talan* тала талан түрэг хэлний монгол хэлний талх түрэг, монгол хэлний талхи зэрэг үгтэй гарал нэгтэй билээ.

М.Рясянен туркмен хэлний *tāla* “эвдэх нураах” уйгур хэлний “урах, таслах, хэлтийх, будлих”, цагаадай осман хэлний казах, ойрд буюу өмнөд алтай хэлний “урах таслах тонох дээрэмдэх” гэх утга осман хэлний *dala* якут хэлний *talā* чуваш хэлний *tula tolla* “хазах, зуух, хатгах, тасар татах > черемис буюу мари хэлний *tola tala taly* “талах, дээрэмдэх”, уйгур хэлний

talym “тонуул, дээрэм, тэмцэл” зэрэг жишээг монгол tala “талах, дээрэмдэх, тонох”, >манж хэлний tala “хураах”, цагаадай хэлний talan” олз, дайны олз”, чуваш хэл > черемис буюу мари хэлний talan эртний орос talanь аз жаргал зол камасин самоед хэлний (Йоки) talan орос казах, сагай аялгууны talan хакас, якут хэлний talān < түрэг хэлний tala “талах дээрэмдэх” гэх үгээс үүссэн гэжээ (1969: 458).

Х.Эрен түрэг хэлний talan “дээрэм тонуул”, азербайжан хэлний talan, туркмен хэлний talan, казах хэлний talan, киргиз хэлний talan, talān, узбек хэлний tālān, якут хэлний talān зэрэг үгийг түрэг хэлний tala- “дээрэмдэх, тонох” гэх үйл үгнээ -n залгавар залгаж үүссэн гэв. Х.Эрен орчин үеийн түрэг хэл, аялгууны хувьд ногай хэлний talau, каракалпак хэлний talau, казах хэлний talau, казань татар хэлний talau гэх баримтыг жагсаажээ. Х.Эрен энэ үг түрэг хэлнээс перс хэлнээ talān talān гэж орсон, тажик хэлнээ tālāš tālān гэж хэрэглэгдэнэ гэв (2000: 392).

В.Г.Егоров чуваш хэлний тула чуваш хэлний аялгуунуудын тавла “нохой зуух, хазлах, эр галуу тонших, тоншиж идэх, чоно барих, идэх, барьж идэх, мэрэх, химлэх, урах, тасдах, тэс үсрэх”, тулаш “химлэлдэх, зулгаалцах, мэрэлцэх, хэрэлдэх”, эртний түрэг хэл, киргиз, казах, узбек, туркмен, татар, башкир хэлний тала, якут хэлний талаа “дээрэмдэх, талах”, уйгур хэлний тали, каракалпак, карачай, казах, татар хэлний тала, азербайжан, түрэг хэлний дала “шүдээр зуух, зуух, тасчих, тасар татах”, В.Вербицкийн алтай хэлний толины тала “сүйтгэх, хоосруулах, сандаах, эвдэх, тасчих, урах, таслах, тасар татах”, ойрд хэлний тала “хараах, доромжлох, нураах, эвдлэх”, эртний уйгур хэлний талым “махчин”, монгол хэлний талах “дээрэмдэх, сүйтгэх, сандаах” зэрэг үгсийг харьцуулсан ба чуваш хэлний тулаш харилцан үйлдэх үйл үг химлэлдэх, зулгаалцах, хэрэлдэх гэсэн утгатай ба киргиз, узбек, татар хэлний талаш, казах, каракалпак хэлний талас, түрэг хэлний далаш “химлэлдэх, зулгаалцах, мэрэлцэх, хэрэлдэх” зэрэг баримтыг харьцуулжээ (Егоров 1964: 256).

Т.Гюленсой Монголын нууц товчооны talan “талаан дээрэм” гэх үгийг түрэг хэлнээс зээлэгдсэн үг гээд уйгур хэлний talamak “талах, дээрэмдэх”, цагаадай хэлний talgan talga talkan “талаан, дээрэм”, киргиз хэлний talaan “талаан, дээрэм” гэсэн жишээг харуулжээ (1973: 105).

Монгол хэлнүүдийн гарал зүйн тольд tala- халх болон халимаг аялгууны тал- “талах, дээрэмдэх, тонох”, халх аялгууны тал- “хөрөнгө хураах” гэх үгсийг эртний түрэг хэлний . tala-, talī- “талах, дээрэмдэх, сүйдлэх, сандаах, үгүйрүүлэх” гэх үгтэй зэрэгцүүлжээ (Санжеев нар, 2018: 150).

Го.Зоригт монгол хэлний тал- tala- / tal- = эртний түрэг хэлний tala- эвдэх, түрэг хэлний talan- булаах, тонох, уйгур хэлний tala-, казах хэлний tala-, киргиз хэлний tala-, узбек хэлний tala-, татар хэлний tala-, азербайжан хэлний talan-, башкир хэлний tala-, туркмен хэл: tāla-. зэрэг үгсийг монгол түрэг хэлний дундын үг гэж тооцжээ (2000: 152).

М.Рясянен түрэг хэлнүүдийн гарал зүйн толиндoo цагаадай хэлний talka “галд шарсан” уйг дундад түрэг хэлний talka-n -буудайн гурил”, казах казань татар хэлний talka-n “хайрч нүдсэн багахан арвай, хайрсан буудайн гурил”, казах хэлний talka-n “нүдэх, нунтаглах, талхлах, жижиглэн хэсэглэх”, > орос хэлний толокно, вогуль хэлний talkan, цагаадай хэлний talgan et “зажлах хивэх”, чуваш хэлний tolə tulə tol tul “улаан буудай” гэх жишээг монгол хэлний talqan тээрэмдэх нүдэх талхлах хуурсан буудайн гурил зэрэг үгтэй зэрэгцүүлжээ (Рясянен 1969: 458).

Б.И.Татаринцев тува хэлний гарал зүйн толиндoo тува хэлний далган “хуурсан арвайн улаан буудайн гурил” гурил тофалар хэлний таылган гурил гурилан эртний түрэг хэлний talqan “хайрсан гурил, нүдсэн гурил” гэх үгтэй харьцуулжээ. Б.И.Татаринцев түрэг хэлний талкан (>талган) гэх энэ үг зүүн түрэг хэлнүүдэд хайрсан гурил нүдсэн гурил гэсэн утгатай байна гэв. Б.И.Татаринцев, А.Т.Кайдаровын казах хэлний талкан “нүдсэн гурил, будаа, хэмхдэг амуу” *тал “задран таслагдсан зүйл” гэхтэй холбосон нь утга зүйн хувьд боломжтой ч бүтцийн хувьд тодорхойгүй байна. Энэ *тал гэх үгийн үндэс казах хэлний дал дал кыл “туг үс болгон, атга болгон тасчих” гэдгийн *дал гэх үндсийн авиа зүйн хувилбар гэж үзэж

болно гэв. Б.И.Татаринцев *дал- “атга үс болгон тасдах” гэсэн үйл үгийн үндэс байсан байж магад гэжээ. Татаринцев түрэг хэлний тала- “эвдэх сандаах, хугалах, нураах” гэх үгийн үндэс мөн тува хэл болон түрэг хэлний нутгийн аялгууст ч тохиолдох тала- шатаах нураах гэх үгсийн гарал тодорхойгүй ч гэсэн энэхүү үндэс дээр дурдсан үгсийн үндэс (Далган гэх үгийн үндэс гэсэн үг. М.У.) лүгээ холбоотой нь илэрхий талка гэх үндэс бий ба Рясянен талкан гэх үгийн гарлыг нь тодруулалгүйгээр цагаадай хэлний талка- “хуурах, нүдсэн гурилыг бэлтгэхэд арвай буудайг хуурах” гэсэн утгыг зааж болох үгтэй харьцуулсан гээд энэ үгнээс бий болсон хоёрдогч үүтгэлд телеут аялгууны талкала “нүдэх, нунтаглах”, киргиз хэлний талкала- зэрэг үг хамаатна гээд энэхүү талка гэх үндсээс –н хэлбэрийн тусламжтайгаар талкан гэх үг үүсэж болох ба энэ үг тухайлбал, тува хэлний далган буюу эхэндээ хуурсан арвай буудайн гурил гэх утгатай байсан үг ч холбоотой гэв. Түрэг хэлний талкан монгол хэлний talqa талх талхан хуурсан гурил, нүдсэн гурил, талх, нунтаг гэх утгатай үгийг Рясянен түрэг монгол хэлний тохирох үгс гэснийг Татаринцев түрэг хэлнээс монгол хэлний зээлэгдсэн үг гэв. Татаринцев далган гэх тува үгийг З.Чадамба, В.И.Рассадин нарын судалгаанд кулур гэх илэрхий монгол үгтэй эсрэгцэх түрэг үг гэж үзсэн ч энэ үгийн утга зүй гадаад дүрс энэ үгийг түрэг эсвэл монгол үг алин болохыг тодорхой заахгүй байна гэжээ (2002: 76).

Монгол хэлнүүдийн гарал зүйн тольд монгол хэлний talqa(n) гэх үгийг халх аялгууны талх “жигнэсэн талх”, буриад аялгууны талхан “гурил, зуурсан гурил, талх”, халимаг аялгууны талхн, монгол хэлний талжа “хуурсан гурил”, дүншаан хэлний табан “хуурсан арвайн гурил” зэрэг жишээгээр харуулаад киргиз хэлний талкан “нүдсэн гурил болсон гурил”, түрэг хэлний talqa “хуурсан гурил, нүдсэн гурил, болсон гурил” гэх үгстэй зэрэгцүүлжээ (Санжеев нар, 2018: 151).

М.Рясянен дундад зууны түрэг хэлний talku “тойрсон эргэлдсэн” казах, казань татар хэлний “шир идээлэх хэрэгсэл”, шор talyk казань татар хэлний talku “олс элээгч” гэсэн үгийг монгол хэлний talki тай холбожээ (1969: 459).

Б.И.Татаринцев тува хэлний далгы “арьс үнгэх”, эртний түрэг хэлний talki-s- “эсгий элдэх өнхрүүлэх”, татар алтай хэл, телеут аялгуу, шор хэлний талкы “арьс үнгэх, идээлэх, олс хугалах”, якут хэлний “ямар нэг зүйлийг нидчих нухчих”, казах татар хэлний талкы “арьс боловсруулах хэрэгсэл, оньс, талхи, хэдрэг”, киргиз хэлний талкуу “арьсны талхи хэдрэг” (<*талкыг, тува хэлний далгыг) “хэдрэг талхи” як талкы уйгур нутгийн аялгууст буй талкан “чийгт тэсвэртэй нэгэн зүйл арьс” гэх үгтэй холбоотой гэж үзжээ

Б.И.Татаринцев тува хэлний энэ үг түрэг хэлний тал- дал- “цохих, дэлдэх, занчилдах” гэх хүчтэй эрчимт үйл заах үгтэй холбоотой байж энэхүү үйл язгуурт кы гэх эрчимжих утгатай хэлбэрийг агуулна гээд монгол хэлний talqi хэмээх үгийг түрэг хэлнээс зээлэгдсэн үг гэв. Б.И.Татаринцев тува хэлний далгы <*талкы талки хэмээх үгийг монгол үг ч байж болох юм гэв (2002: 76).

Монгол хэлнүүдийн гарал зүйн тольд talki [←* talqi] гэх үгийг халх аялгууны талхи(н), буриад аялгууны талхи, халимаг аялгууны талк, талк “арьс талхигч хэдрэг”, буриад аялгууны “олонцоггүй эмээл”, халх аялгууны түүхэн утгаараа “эрүүдэх хэрэгсэл”, шилжсэн утгаараа “талхидал дарлал” гэх үгсийг киргиз хэлний талкуу “арьс талхигч, хэдрэг”, түрэг хэлнүүдийн тюрк. talqıq эмээл. talki- халх, буриад аялгууны талхи-, халимаг аялгууны талк- “талхи хэдрэгээр арьс элдэх” гэх мэт үгийг эртний түрэг хэлний talqis- “хэн нэгэнтэй эсгий хийх эсгий элдэх” гэх үгтэй зэрэгцүүлжээ (Санжеев, Орловская, Шевернина 2018: 151).

Б.И.Татаринцев тува хэлний далбый “шаантаг хэлбэртэй модон цас цэвэрлэгч, шаантаг, шанцаг” гэх үгийг бусад түрэг хэлнээ тохиолдоггүй гээд эртний түрэг хэл, Кашгарын Махмудын толины taluq “сүхний үзүүрийг сүхний ишинд бэхлэх шаантаг”, taluic “амьтны нуруунд ачааг бэхлэхэд ашиглах саваа, савх мөн шаантаг, шанцаг, хадаас ачааг бэхлэхэд хэрэглэх шаантаг” гэх үгтэй харьцуулж болно гэж өгүүлжээ. Б.И.Татаринцев Рясянены тольд эртний уйгур хэлний taluk “хадаас”, Кашгарын Махмудын толины taluk шор хэлний talyk talyl “шаантаг шанцаг”

гэх үгсийг харьцуулсан ч огт задлан шинжилсэнгүй тэгээд ч шаантгийг заах шор хэлний хоёр хэлбэрийн хоорондын ялгааны уугуул шинж тодорхойгүй энд хоёр дахь хэлбэр нь авиа тонгорч үүсжээ гээд, түүнчлэн шор хэлний *taluk* талык гэх үг арьс идээлэх хэдрэг талхи гэх утга заадгийг онцлох хэрэгтэй гэв. Б.И.Татаринцев, мөн Э. В. Севортян эртний түрэг хэлний *talguk* “сүхний ишийг бэхлэх шаантаг, хадаас” гэх үгийг дурдсан ч ямар үйл үгийн үндсээс үүссэнийг заасангүй гэжээ. Б.И.Татарницев, “эртний түрэг хэлний хэрэглэгдэхүүнд тулгуурлан *tal-* хэмээх үйл үгийн үндэс буй гэж ярьж болно. Энэ үгийн үндсээс -үйс залгавраар *talүйс* гэх үг үүсжээ. Энэхүү үндэс хуваагдах бүхэл нь эвдрэх гэх утгыг заадаг гэж таамаглаж болно” гээд **tal* гэх үндсийг орчин цагийн түрэг хэлний *dal-* “хурдан хурдан живэх, шумбан орох, шурган орох, орох, нэвтрэх цэргийн утгаар цөмрөн орох”, цагаадай хэлний талга” салгах хуваах” -га -ка давтах эрчимжих утгатай залгавар уйгур хэлний лобнор аялгууны тала “урах, таслах, салгах, хагалах” гэх үгтэй харьцуулж болно хэмээн дурдав. Түүнээс гадна, Б.И.Татаринцев дээрх үгстэй эртний түрэг хэл, Кашгарын Махмудын толины *talgiү* эмээл уулын уулзвар газар *gi-* нь эрчимжих утгатай залгавар, -ү- үйлээс нэр үг үүсгэх хэлбэр **tal-* *dal-* гэх үл үгийн үндэс Е.З.Кажобековын үзлээр *dal-* туг үүснээ зүйлийн бүхэл шинжийг эвдэх утгатай үгтэй холбоотой гэжээ. Тува хэлний далбый гэх үг дээрх үйл үг нэр үгийн үндэстэй нэг гаралтай энэ үг анхлан **тал-пы-й* гэсэн хэлбэртэй байж *тал-* нь дээр дурдсан үйл үгийн үндэс болж *пы-* эрчимжих давтах -й-нь нэр үг үүсгэх хэлбэр гэжээ (2002: 74-75).

М. Базаррагчаа “эртний монгол хэлний *тал-ка-ла-ку* “талхлах”, *тал-ки-ку* *тал-ки* *ал-ки-ку* *тол-ки-ку* зэрэг үгийн тэргүүн үеийг хаасан л нь ла үе байснаа задарчээ. энэ ла үе нь та- хэмээх нөхөцмөл язгуурын дараа орж, та-ла-ку “талах” болж т нь гээгдэн а-ла-ку “алах” хэмээх үг бүтээжээ. Энэхүү ла үе нь ну үетэй сэлгэж, тануку танах та- ну-г танаг гэсэн үг бүтэх ба ну нь үе задарч н болох ба8 уул н нь м тэй сэлгэж та-м-ту-ри-ку тамтрах та-м-ту-г тамтаг хэмээх үг салаалжээ. Монгол хэлний та-ну-ку гэдгийн а нь о той сэлгэж, то-ну-г “тоног”, то-ну-ку “тонох” хэмээх үг үүсчээ. Эдгээр үг нь алив юмыг талхлан багасгах оронцог болгох гэсэн утгатай ажээ” гэв (1994: 447-448).

М.Базаррагчаа “эртний монгол хэлний *а-с-ки-ку* “асхих, зодох жанчих” хэмээх үгийн с нь л ээр сэлгэж *ал-ки-ку* “алхих”, улмаар анхандаа *тал-ки* “талхи-арьс элдэх, хэрэгсэл”, *тал-ки-ку* “талхих” гэж т гийгүүлэгчтэй хэлж байжээ. Үүнээс тэргүүн үеийн эгшиг сэлгэж *тол-ки-ку* “толхих”, *тул-ки* “тулхи”, *түл-ки-кү* “түлхэх”, *тэс-ки-кү* “тэсгэх, алах” *тал-ка-ла-ку* “талхлах”, *тал-ка* “талх”, *тул-ка* “тулх, тух”, *тул-ку* “тулах” зэрэг үг бүтжээ. Тэрчлэн *ас-ки-ку* гэдэг нь “огтлох, таслах, хэсэг болгох” гэсэн утга бүхий *эд/с-гэ-кү* “эсгэх”, *эс-кү* “эсэх, эсгэх” *э/и с-кү* “эсэх исэх”, *кэ-сэ-г* “хэсэг”, *э-с-гэ-л* “эсгэл агтлах”, *а-са-ма-н* “асман”, *ас-ка-ку* “асгах”, *а-са-г* “асаг үе мөчний заагт үүсэх өвчин” зэрэг үгтэй а э гийн сэлгэцээр холбогдох ажээ” хэмээн бичжээ (1994: 462).

Монголын нууц товчооны 130 дугаар зүйлд *bawurči Šiki'ür-i ašgiju'ui* (Лигети, 1971: 86) гэж гарах ба энэ үгийг хятад хадмалд зодох занчих (Панкратов, 1962: 176) хэмээн орчуулсан бөгөөд судлаачид санал нэгтэй зодож занчих хэмээн ухаарч буулгадаг. Энэ үгийг Д Цэрэнсодном орчин монгол хэлний алхих гэх үгтэй нэг гаралтай гэж үзжээ (1993: 357) Зуунаст Цэцэнцогт нар Субашид зохиолд энэ үг тохиолддогийг (Зуунаст, Цэцэнцогт 1989: 122) мөн К.Ф.Голстунский “Үлгэрийн далай” зохиолд зодох цохих гэсэн утгатай аскику хэмээх үг байдгийг дурджээ (1894: 24). Бид Монголын нууц товчооны энэхүү үгийг тасартал занчих гэсэн утгатай гэж үзсэн юм (Ууганбаяр, 1996:21). Хамниган-манж хэлнүүдийн харьцуулсан тольд гарах *асих`а* манж хэлний *асих`а* хэрчих тайрах мөчирлөх тас цавчих гэх үг ч энэхүү үгтэй гарал нэгтэй байх (ССТМЯ I, 1975: 56).

Ном зүй

- Азербайжанча-русча лүгэт. Тәртиб едәни Х. Ә. Әзизбәјов. Азербайджанско-русский словарь. **Базаррагчаа М.** 1994. *Монгол үгийн гарлыг мөшгих нь*. III-V. Улаанбаатар.
- Составитель Х.А.** 1985. Азизбеков. Баку Баку.
- Голстунский К.Ф.** 1894. *Монгольско-русский словарь*, том I-II. Санкт-Петербург.
- Егоров В.Г.** 1964. *Этимологический словарь чувашского языка*. Чебоксары.
- Зоригт Го.** 2000. *Монгол төрлийн хэл ба түрэг төрлийн хэлний үгсийн харьцуулсан судлал*. Хөх хот.
- Кыргызча-орусча сөздик. Кыргызско-русский словарь. Составитель К. К. Юдахин. Бишкек. 2019.
- Лувсанжав Чой., Шархүү Ц.** 1968. *Манж-монгол толь*. Улаанбаатар.
- Сажа бандид Гунгаажалцан.** 1989. *Сайн үгт эрдэнийн сан нэрт шашидир*. Тарнич Сономгара орчуулав, Зуунаст, Цэцэнцогт харгуулан тайлбарлав. Хөх хот.
- Санжеев Г.Д., Орловская М.Н., Севернина З.В.** 2015. *Этимологический словарь монгольских языков, Том I А-Е*. Москва.
- Санжеев Г.Д., Орловская М.Н., Севернина З.В.** 2016. *Этимологический словарь монгольских языков, Том II. G- P*. Москва.
- Санжеев Г.Д., Орловская М.Н., Севернина З.В.** 2018. *Этимологический словарь монгольских языков, Том II. Q- Z*. Москва.
- Севортян Э.В.** 1974. *Этимологический словарь тюркских языков: Общетюркские и межтюркские основы на гласные*. Москва,
- Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков: Материалы к этимологическому словарю. Том I. А-Н.* 1975. Ответственный редактор В. И. Цинциус. Ленинград.
- Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков: Материалы к этимологическому словарю. Том II. О-Э.* 1977. Ответственный редактор В. И. Цинциус. Ленинград.
- Сүхбаатар О.** 1997. *Монгол хэлний харь үгийн толь*. Улаанбаатар.
- Татаринцев Б.И.** 2000. *Этимологический словарь тувинского языка Том-I А, Б*. Новосибирск.
- Татаринцев Б.И.** 2002. *Этимологический словарь тувинского языка, Том II Д, Ё, И, Й*. Новосибирск.
- Татарско-русский словарь*. Под редакцией профессора Ф.А.Ганиева. Татарча-русча сүзлек. Профессор Ф.А. Ганиев редакциясендэ. 1995. Казань. Казань.
- Ууганбаяр М.** 1996. *Монголын нууц товчооны зарим үг хэллэгийн тайлбар I*. Улаанбаатар.
- Фасмер М.** *Этимологический словарь русского языка*. 1986. В четырех томах. Перевод с немецкого и дополнения члена-корреспондента АН СССР О. Н. Трубачева. том I (А-Д). Москва.
- Фасмер М.** 1987. *Этимологический словарь русского языка*. В четырех томах. Перевод с немецкого и дополнения члена-корреспондента АН СССР О. Н. Трубачева. том IV (Т-Ящур) Москва.
- Цэрэнсодном Д.** 1993. *Монголын нууц товчоо орчуулга тайлбар*. Хөх хот.
- Цэцэнцогт.** 1988. *Монгол үгсийн язгуурын толь*. Жанг Жияа Кеү.
- Щербак А.М.** 2005. *Тюркско-монгольские языковые контакты в истории монгольских языков*. Санкт-Петербург: Наука.
- Юань-Чоа-Би-Ши.** 1962. *Секретная история монголов 15 цзюаней*. I текст издание текста и предисловие Б. И. Панкратова. Москва.

- Clauson G.** 1959-1960. *Turkish Elements in 14-th Century Mongolian*. Central Asiatic Journal 5.
- Doerfer G.** 1965. *Türkische und mongolische Elemente im Neupersischen*. Unter besonderer Berücksichtigung älterer neupersischer Geschichtsquellen vor allem der Mongolen-und Timuridenzeit Bd II. Türkische Elemente im Neupersischen alif bis tā. Wiesbaden.
- Eren H.** 1999. *Türk Dilinin Etimolojik Sözlüğü*. Ankara.
- Gülensoy T.** 1973. *Moğolların Gizli Tarihi`ndeki Türkçe Kelimeler Üzerine bir Deneme Türkoloji Dergisi* 5 1. Ankara.
- Joki A.J.** 1952. Die Lehnwörter des Sajansamojedischen Helsinki. Mémoires de la Société Finno-Ougrienne 103.
- Kotwicz W.** *Les éléments turcs dans le langage mandchoue Rocznik orientalistyczny*. t XIV. 1938. Lwów, 1939.
- Ligeti L.** 1971. *Histoire Secrète des Mongols*. Budapest.
- Räsänen M.** 1969. *Versuch eines etymologischen Wörterbuchs der Türksprachen*. Helsinki.

Summary

In this paper, the author presents some of his research results on the origin of some Turkish and Mongolian words. In particular, the author concluded that the Turkish word aş "food, meal" is etymologically related to the Turkish word alma "apple" and the Mongolian alima "apple"; and the Turkish word talan "to rob" is etymologically related to the Mongolian word tala- "to rob", ala- "to kill".